



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2028 оны 04 сарын 24 өдөр

Дугаар А/249

Алтай хот

**Ц.Лоохуузын нэрэмжит аймгийн
Музейн үзэл баримтлалыг
батлах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны "Аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай 10 дугаар тогтоол, "Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай" 11 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:


- 1.Цогт-очирын Лоохуузын нэрэмжит Говь-алтай аймгийн Музейн үзэл баримтлалыг хавсралтаар баталсугай.
- 2.Музейн үзэл баримтлал, үзүүлэг дэглэлтийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллахыг аймгийн Музей (Ц.Оюунзул)-д үүрэг болгосугай.
- 3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (С.Мөнхжаргал)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР

Аймгийн Засаг даргын 2023 оны 4-
дугаар сарын 24-ны өдрийн 24 дугаар
захирамжийн хавсралт



АЙМГИЙН МУЗЕЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг. Музейн үзүүлэлийн үндсэн чиглэлийг шинэчлэх үндэслэл, хэрэгцээ, шаардлага:

Аймагт Орон нутаг судлах кабинет байгуулах төлөвлөгөөг МАХН-ын Төв хороо, Сайд нарын зөвлөлийн 1947 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 73/28 дугаар тогтоолоор баталсан нь өнөөгийн аймгийн Музейн үүсэл болсон.

Одоогийн үйл ажиллагаа явуулж байгаа музейн барилга 2 давхар нийт 835 мкв, үүнээс: сан хөмрөгийн өрөө 1, (36.6 мкв) үзмэрийн танхим 8, (766.3 мкв), албан өрөө 3, (52.6 мкв), барилга нь 1957 онд аж ахуйн аргаар баригдаж, уг оны газар хөдлөлтөөр ан цав гарсаныг аймгийн барилгын комиссууд, улсын барилгын Эдийн засгийн зөвлөлийн мэргэжилтнүүд шалган үзээд барилгыг засварлах хүртэл уул барилгын 2 давхарт байгаа байгалийн тасгуудын үзмэрийг 1 давхарт шилжүүлэх шийдвэр гаргаж, улмаар АДХ-ын гүйцэтгэх захиргааны 1964 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 173 дугаар тогтоол гарсан байна. 1998, 2004 онуудад дээврийг удаа дараа засварлаад байдал сайжраагүй, хур тунадас ихтэй үед дээврээс ус орох засвар хийсэн хана тааз байнга нурдаг. 2008 онд 7,0 сая төгрөгөөр дээвэр засварлахад нуруу мод солиогүйн улмаас бороо, цас орох бүрд дусаал гоожиж үзмэрийн танхимууд тааз нуралт үүссэн байна.

Мэргэжлийн хяналтын газрын Барилга техникийн хяналтын улсын байцаагчийн 2008, 2012 онуудад хийсэн үзлэг шалгалтаар үйл ажиллагаа явуулах шаардлага хангахгүй гэсэн дүгнэлт гарсан. Одоо үйл ажиллагаа явуулж байгаа барилга нь аж ахуйн аргаар баригдсан стандартын бус дулаан, цэвэр бохирын систем тавьсан, агааржуулалтгүй, ослын гарцгүй үйлчилгээ явуулахад тохиромжгүй, суулт өгсөн, байнга цантаж, хөгц мөөгөнцөр үүссэн, эргэн тойрон цууралт үүсч ан цав гарсан дээврийн нуралт байнга өгч байгаа нь түүхийн дурсгалт зүйлс, хүний эрүүл мэнд амь нас хохирох байдалд хүрч болзошгүй тул музейн стандартын барилгатай болох хэрэгцээ шаардлага тулгарсан юм.

Шинээр барилга бариулж, түүх, соёлын дурсгалт зүйлс, үзмэр эд өлгийг аюулгүй найдвартай орчинд хадгалж, сурталчилах, сургалт танин мэдэхүйн үйл ажиллагаа явуулах, цаашлаад аялал жуулчлалыг татах нь бидний нэн түрүүнд анхаарвал зохих асуудал бөгөөд холбогдох шат шатны байгууллагад танилцуулж санал хүргүүлэн шинээр 30.2м x 29.9м харьцаатай 2 давхар, зоорьгүй цутгамал төмөр бетон карказ хийцтэй барилга аймгийн Есөнбулаг сумын, Баянхайрхан багт баригдаж "Ди Ди Эй Жи" ХХК барилгын ажлыг хийж гүйцэтгэж байна.

Манай аймаг нь уулт хээр, хээр, говийн бүс хосолсон байгалийн өвөрмөгц тогтоцтой, ашигт малтмалын арвин нөөц, ан амьны төрөл зүйлээр баялаг, хүн төрөлхтөний нэн эртнээс эдүгээг хүртэл буй болгосон түүх соёлын дурсгалтай, баруун Монголчуудын өлгий нутаг билээ.

Шинээр дэглэх аймгийн музей нь Орон нутгийн түүх, соёлын өвийг цуглуулах, бүртгэн баримтжуулах, хадгалах хамгаалах, судлан шинжлэх, үндсэн

2.

үүрэгтэй, орон нутгийн бахархалыг ард иргэдэд ойлгуулах, таниулах, эх оронч хүмүүжилийн боловсрол олгох, өөрийн орон нутгийн онцлог, түүхийг үнэн бодитоор таниулах зорилготой, аялал жуулчдад нутгаа сурталчилах үйлчилгээ үзүүлэх зэрэг олон чиглэлийн үйл ажиллагаа явуулах соёлын байгууллага юм.

Хоёр. Шинэ Музейн барилгын хэлбэр хийц, бүтэц зохион байгуулалт.

Шинээр баригдаж буй музейн барилга нь: Есөнбулаг сумын, Баянхайрхан багт Төв номын сан, Онцгой байдлын газрын дунд баригдаж байгаа бөгөөд иж бүрэн зураг төслийг аймгийн Засаг даргын Тамгын газрын захиалгаар Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын даргын баталсан 2017 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн архитектур төлөвлөлтийн даалгаврыг үндэслэн зураг төсөв боловсруулах гэрээ байгуулан, захиалагч талтай зөвшөөрөлцсөн эскизийн дагуу, инженер геологийн дүгнэлтийг үндэслэн барилгын зураг төслийг "Ди Ди Эй Жи" ХХК тус тус боловсруулан бүтээн байгуулалтын ажил хийгдэж байна. Ажлын зургийн баримт бичгийг дараах байгаль цаг уурын нөхцөл, барилгын ангилалын зэргүүдэд тооцож гүйцэтгэж байна.

Гадна агаарын температур 26,2°C, цасны ачаалал 50кг/м², салхины ачаалал 31,7кг/м², эдэлгээний зэрэг 2, галын аюулгүй категори 2, гал тэсвэрлэлтийн зэрэг 2, газар чичирхийлэлтийн зэрэг 9 балл, барилгын ангилал нь олон нийтийн барилга юм.

Музейн барилга нь 30.2м х 29.9м харьцаатай 2 давхар, зоорьгүй цутгамал төмөр бетон каркас хийцтэй. Барилгад сүүлийн үед хэрэглэж буй Монгол Улсын стандартад тохирсон материал, технологи ашигласан, барилгын хийц, өнгө үзэмжийн хувьд тухайн орчин болон барилгын зориулалтад бүрэн нийцсэн, үйлчлүүлэгч болон ажилчдын ажиллах нөхцөл, аюулгүй байдал, тав тухыг хангахуйц орчин үеийн шийдэл бүхий барилга байгууламжийг төлөвлөсөн. Үйл ажиллагааны функц нь ажилчдын буюу дотоод үйл ажиллагааны, үзмэрийн хэсэг буюу үйлчлүүлэгчдэд зориулсан 2 хэсэгт хувааж төлөвлөжээ.

Музейн барилгын 1 давхарт үйлчлүүлэгчдийн хэсэгт үүдний танхим, өлгүүр, амрах талбай, хурлын танхим, үзвэрийн 1 танхим, ариун цэврийн өрөө, ажилчдын хэсэгт хамгаалалтын алба, үзмэр хүлээн авах, сан хөмрөг, албан тасалгаа, ажилчдын амралтын, хувцас солих, техникийн өрөөнүүд, 2 давхарт үзвэрийн 5 танхим, дотоод хэсэгт музейн ажилчдын албан тасалгаанууд, музейн захирал, уулзалтын өрөө гэх тасалгааг норм дүрмийн дагуу төлөвлөсөн, техникийн давхарт Лифтний техникийн өрөө, агааржуулалтын техникийн өрөө тус тус байна.

Гурав: Музейн үйл ажиллагааны чиглэл хамрах хүрээ:

Аймгийн Музей нь орон нутгийн хэмжээнд соёлын өвийг бүртгэх, хадгалж хамгаалах, судлах хойч үедээ сурталчилах, иргэдийн оюуны тодорхой эрэлт хэрэгцээг хангах, улмаар нийгмийн хөгжилд үр нөлөө үзүүлэх, цаашид тогтвортой хөгжих чадаах бүрдүүлэх замаар музейн үйлчилгээний чанарыг шинэ түвшинд гаргах сургалт судалгааны цогц үйлчилгээний байгууллага юм.

Мөн орон нутгийн төрийн ба төрийн бус байгууллагатай нягт уялдаа холбоотой ажиллаж үзүүлэгч дэглэлт, техник технологийн дэвшил соёлын бүтээлч үйлдвэрлэл, эвент үйл ажиллагаа зохион байгуулж үйлчлүүлэгчдэд соёлын өвийн мэдлэг боловсрол олгох соёл, эрдэм шинжилгээ, судалгаа, үйлчилгээний байгууллага юм.

3.

Аймгийн Музей нь орон нутгийн байгалийн өв, түүх соёлын дурсгал, түүхэн үйл явдал, алдартнууд, орон нутгийн хөгжлийн түүх, угсаатан, соёлын биет ба биет бус өвийн мэдээллийг хадгалах бүртгэл мэдээллийн сан, үзмэр эд өлөгийг хадгалах сан хөмрөг, хурал цуглаан биет бус өвийг бүртгэх, тайлан тоглолт зохион байгуулах танхим, архив, судалгаа шинжилгээ, үйлчилгээ үзүүлэх ажилтнууд бүхий үндсэн үйл ажиллагааг явуулна.

Мөн тус Музей нь орон нутгийн соёлын өвийг хамгаалах, боловсрол танин мэдэхүйн сургалт, судалгаа, өв соёлыг сурталчилах түгээн дэлгэрүүлэх, аялал жуулчлал, байгаль орчны мэдээллийн, орон нутгийн судалгаа шинжилгээний төвийн үүргийг давхар хүлээх ба бэлэг дурсгалын дэлгүүр, эвент арга хэмжээг туслах чиглэл болгон зохион байгуулж хөгжүүлнэ.

1.Орон нутгийн соёлын өвийг хамгаалах төв

Баруун бүс нутгийн соёлын өвийг эрэн сурвалжлах, бүртгэх, авран хамгаалах ажлыг мэргэжлийн байгууллагатай хамтран хийх, соёлын биет болон биет бус өвийн судалгааг мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулах, соёлын өвийн хадгалалт хамгаалалтад үзүүлэх сөрөг нөлөө эрсдэлийг анхаарч ажиллах үүргийг хүлээнэ.

2.Боловсрол, танин мэдэхүйн сургалт, судалгааны төв

Говь-Алтай аймгийн нутаг дахь түүх соёлын дурсгалын бүртгэлийг тогтмол хийж, судалгааны хэрэглэгдэхүүн баазыг нэмэгдүүлж, санаачилгатай ажиллах ба гадаад, дотоодын мэргэжлийн судлаач эрдэмтэдтэй хамтран ажиллах, мэргэжлийн байгууллагуудтай хамтран судалгаа шинжилгээний ажлуудыг зохион байгуулах хуулийн дагуу малтлага судалгааг явуулж олдворын сантай болох, орон нутгийн сургалт судалгаа танин мэдэхүйн ажлыг эрчимжүүлнэ.

3.Өв соёлыг сурталчилах түгээн дэлгэрүүлэх

Сумдын Соёлын төв болон соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчидтай нягт уялдаа холбоотой ажиллах, жил бүр тогтмол арга хэмжээг зохион байгуулах соёлын биет бус өвийг сурталчилах олон нийтийн ажлыг зохион байгуулна.

4.Аялал жуулчлал, байгаль орчны мэдээллийн төв

Аялал жуулчлалын хэрэгцээт бүх мэдээлэл болох аялалын маршрут, жуулчны баазууд, зочид буудал зоогийн газруудын мэдээ мэдээллийг нэгтгэх, танилцуулга өгөх, гадаад дотоодын жуулчдад орон нутгаа нээлттэй танилцуулж сурталчилахын зэрэгцээ орон нутгийн хөгжилд тодорхой хувь нэмэр оруулах ажлыг хийж гүйцэтгэнэ.

5.Эвент арга хэмжээ зохион байгуулах

Аймгийн төрийн болон төрийн бус байгууллага, хувь хүмүүсийн зохион байгуулж буй соёл уламжлалын арга хэмжээ, улирлын чанартай эвент арга хэмжээ, уралдаан тэмцээн наадам зэрэг зохион байгуулагдаж буй орон нутгийг сурталчилах ажилд санаачлагатай оролцоно.

6.Тодорхой санхүүжилт эх үүсвэртэй болох

Музей шилдэг үзмэр, орон нутгийн өвөрмөц байгаль, онцлог зүйлүүдэд түшиглэсэн бэлэг дурсгалын дэлгүүр, үйлчилгээний хэсэгтэй байна.

Дэлхийн аль ч нэр хүндтэй том музейд тухайн музейнхээ сор болсон бүтээлүүд, олдворууд, үнэ цэнэтэй чухал зүйлүүдээсээ хуулсан, санаа авсан бэлэг дурсгалын зүйлийг худалдаж орлого бүрдүүлэх хэсгүүд байдаг.

4.

Ховор чухал судалгааны баримт, баримтат киног төлбөртэй үзэх, аймгийн түүх соёлын үл хөдлөх дургалын талаарх өнгөт альбом, ном катологи, бичлэгүүдийг худалдан нэмэлт орлого олно.

Дөрөв: Музейн үзүүлэлэг дэглэлтийн ерөнхий төлөвлөгөө:

Тус музей үзүүлэлэг нь орон нутгийн байгаль, газарзүй амьтан ургамал, түүх, угсаатны бүлэг, тэдний ахуй амьдрал, соёлын биет ба биет бус өвийг сурталчилан таниулах мэдээлэл өгөх зорилготой.

Музейн сан хөмрөгт 2509 дэсийн үзмэр эд зүйл хадгалагдаж байгаа бөгөөд үзмэрийн төрөл зүйлээр авч үзвэл байгалийн үзмэр эд зүйл 349, (14 хувь), түүхийн холбогдолтой 539 (22 хувь), угсаатны зүйн холбогдолтой 564 (23 хувь), шашны холбогдолтой 740 (30 хувь), архелогийн холбогдолтой 130 (5 хувь), байгалийн 349 (14 хувь), Палеонтологийн 32 (1 хувь) тус тус эзэлж байна.

Шинээр баригдаж буй музейн үзүүлэлэгийн дэглэлтийг төлөвлөхдөө:

1. Байгалийн танхим 90,76 м²
2. Түүхийн танхим 107,65 м²
3. Угсаатны зүй, соёлын биет бус өвийн танхим 80,25 м²
4. Шашины танхим 78,71 м²
5. Алдартны болон вертуал танхим 87,39 м²

Байгалийн танхимд: Монгол Улс албан ёсоор нэгдэж, дагаж мөрдөх үүрэг хүлээсэн Олон улсын байгаль хамгааллын хэд хэдэн конвенцэд орсон биологийн ховор зүйлүүд Говь-Алтай аймгийн нутаг дэвсгэрт олон бий. Эдгээрээс Олон улсын хэмжээнд ховордлын зэргээрээ өндөрт тооцогддог, устаж болзошгүй болон ховордсон зүйлийн жагсаалт, биологийн олон янз байдлын нарийн шүүлтүүрийн бүрдэл хэсэг болсон онцгой чухал зүйл амьтад болох говийн 6 гайхамшигт амьтанг онцлон тодруулж дэглэх ба эртний ургамал амьтны үлдэц, эрдэс чулуулагийн дээж, ан амьтан, ургамалын цуглуулгыг шинжлэх ухааны үндэслэлтэй биологийн ангилал зүйн дарааллаар орчин бүрдүүлэн дэглэнэ.

Түүхийн танхимд: Эртний хүн сүргийн оршин амьдарч байсан орчин бүрдүүлэн хуулбараар дэглэн харуулах, чулуун зэвсэг өнгөт чулуу, цахиураар чулуун зэвсэг хийж байсан үл мөр бүхий газар нутгийн байршил, схем загвар, чулуун зэвсгийн олдворууд, хүрэл зэвсгийн олдворууд хосгүй үнэт үзмэр "Хүрэл морь"-ийг тодруулан харуулах, буган хөшөө, хадны зураг, дөрвөлжин булш хиргисүүрийн тайлбар, зурагт самбар, зарим дурсгалын хуулбар, төмөр зэвсгийн үеийн олдворууд, манжийн өмнөх ба дараах үеийн Засагт хан аймгийн холбогдолтой дурсгалууд, аймгийн нэршил өөрчлөгдсөн зурагт мэдээллийн самбар, аймгийн түүхийг харуулсан жижиг контентууд, 1921 оны ардын хувьсгалаас өмнөх ба дараах үеийн аймгийн улс төр, нийгэм эдийн засгийн байдлыг тоймлон харуулсан зурагт самбар мэдээ мэдээл биет үзмэр, аймаг байгуулагдсан нь (Алтай аймаг анх төвлөрөх үеийн ерөнхий тойм, анхны сумдын зохион байгуулалт) Нэгдэлжих хөдөлгөөн, хөдөө аж ахуйг нийтээр хоршоолсон түүх зэрэг он цагийн дарааллаар музейн сан хөмрөгт тулгуурлан зарим үзмэрийг хуулбар хэлбэрээр үзүүлэгийг дэглэнэ.

Шашны танхимд: Тухайн орон нутагт амьдарч ирсэн ард түмний мөнх хөх тэнгэрээ шүтэн, эх газар дэлхийгээ хүндэлж ирсэн соёл, ёс заншил, эдлэл хэрэгсэл, тэдгээрийг хэлбэр хийц, он цагийн дараалал, хийгдсэн материал зэргээр нь төрөлжүүлэн шашины холбоотой үзмэр эд өлгөөр шашины хэсгийг дэглэж

үзүүлнэ. Үүнд: Судар, эрхи, сац суварга, хонх, дамар, сангийн бойпор, зурмал болон шуумал бурхад зэргийг витринд дэглэх мөн аймгийн нутагт байсан сүм хийд гол шүтээн шавилан сууж байсан лам нарын тоо зэрэг мэдээлэл байрлуулах. Аливаа зан үйл гэдэг ямар нэгэн үйл хөдлөл, орон зайнаас хамааралтай учир музейн үзмэрийн хэмжээнд биетээр харуулах боломж бага учраас гол төлөв техник, технологийн тусламжтайгаар цогц хэлбэрээр харуулах боломжтой гэж үзэж байна. Засагт хан аймагт 28 том сүм хийд байсан ба 3 тамгатай хутагт энэ аймагт харьяалагдаж байжээ. Үүний нэг нь Бигэр Номун хааны хүрээ хийд одоогийн аймгийн нутаг дэвсгэрт байгаа хийдийн туурь нь Бигэр сумын нутаг дахь түүх соёлын үл хөдлөх дурсгалыг улсын хамгаалалтад оруулсан байна. Мөн тэдгээрээс музейн сан хөмрөгт шашины 740 дэсийн 1231 ширхэг шашины үзмэр эд зүйлд тулгуурлан дэглэн харуулна.

Угсаатны зүйн танхимд: Энэ танхимд орон нутгийн ард түмний амьдралын хэв шинж, бэлчээрийн мал аж ахуй соёл, ёс заншил, уламжлалт аж ахуйтай холбогдох өвийн хэсэг, мал аж ахуй, газар тариалантай холбогдсон уналга ачилга, малын тамга, газар тариалан эрхлэх багаж хэрэгсэл зэрэг эдлэл хэрэглэлүүдийг оруулна. Ан агнуурын аж ахуйтай холбогдох эдлэл хэрэгслүүд, багаж хэрэгсэл (эртнээс нааш ашиглаж ирсэн ангийн зориулалттай буу, хавх, зэрэг хэрэглэл) орно. Мөн ан агнууртай холбоотой хорио цээр, ан агнах арга ухаан, зан үйлийн талаарх мэдээллийг харуулсан зурагт самбар, баримт, дүрс бичлэг зэргийг ашиглана. Гэр орон сууц, хоол унд, уламжлалт мэдлэг ухаан, танин мэдэхүйн хэсэгт 4 ханатай гэр, гэрийн тавилга сэлтийн хамт дэлгэн үзүүлэх, мөн уламжлалт мэдлэг ухаан, танин мэдэхүйн хэсгээр уламжлалт тоглоом наадгай, гоёл чимэглэл, ардын уламжлалт дуу хуур, хөгжим, уламжлалт эмчилгээ, анагаах ухаантай холбогдох үзмэр, соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдын мэдээллийг харуулсан үзүүлэн орчин үеийн техник технологийн дэвшил ашиглан видео болон контент хэлбэрээр үзүүлэгээ дэглэнэ.

“Жангар” вертуал танхим:

Музейн интерактив үзүүлэлийн агуулга: Жангар тууль соёлын биет бус өв, хадны зураг түүх соёлын үл хөдлөх дурсгал, угсаатны бүлэг бүхий Галдан хааны түүх Өөлдүүдийн тухай мөн байгалийн танхимд эрт галавын амьтад, үлэг гүрвэлийн ертөнцийн тухай, говийн гайхамшигт 6 амьтан зэргийг харуулсан орчин үеийн техник технологи ашиглан интерактив хэлбэрээр харуулна.

Эдгээрийг интерактив үзүүлэгээр үзүүлэхдээ:

1.Жангар тууль, соёлын биет бус өвийн тухай

Монгол Улсын яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн үндэсний бүртгэлд багтсан “Монгол Жангар хайлах” өвийг сэргээх, хадгалан хамгаалах, өвлүүлэн үлдээх зорилгоор уран зохиолын оргил гэгдэх “Баатарлаг Жангар” туулийг 1000 туульч Говь-Алтай аймагт маань хайлсан. Үүнийг орон нутгийн ялгарал болгон харуулах түгээн дэлгэрүүлэх сурталчилах ажлыг хийж гүйцэтгэх ба туулийн талаар, соёлын биет бус өвтэй холбоотой видео контент хийх

2.Галдан хаан ба Өөлдүүд

Галдан хаан амьдралынхаа сүүлчийн жил орчмын хугацааг зугтан дутаах байдалтай явж өнгөрүүлсэн ба түүний амьдарч нутаглаж оршсон газар бол Говь-Алтай аймаг юм. Түүний үр хойч болох Өөлдүүд Говь-Алтай аймгийн зарим

6.

сумдад угсаатны бүлгийн тодорхой хувийг эзлэн амьдарч байна. Галдан хааны түүхтэй холбоотой баримт мэдээлэл бүхий VR төхөөрөмжөөр интерактив контент хийх.

3.Хадны зураг

Алтайн нуруу дамнасан уул нуруунд орших өвөрмөц хэлбэр дүрслэл, агуулгатай хадны зургийг түүнийг бүтээх үйл явцаас эхлэн өнөөдрийг хүртэл хадгалагдан үлдсэн байдлыг интерактив байдлаар харуулах контент

4.Эрт галавын орчин ба амьтад

Эрт галаваас өнөөдрийг хүртэлх говийн байгаль, цаг агаар, хүрээлэн буй орчны өөрчлөлт, Палеонтологийн үзүүлэгийн давхрын хэсэгт VR төхөөрөмж ашиглан эрт галавын нэгэн цагт говь нутагт идээшин байсан үлэггүрвэлийн ертөнцөөр аялах боломжтой интерактив контент харуулсан мультимедиа контентийг хана дотор тусгай зориулалтын проекторууд ашиглан анимейшн хэлбэрээр үзүүлэх.

5.Говийн 6 гайхамшигт амьтны тухай

Говь-Алтай аймгийн нутаг дэвсгэрт дэлхийн хэмжээнд ховордлын зэргээрээ анхаарал татсан биологийн олон зүйл томоохон болон жижиг хөхтөн, шувууд, хоёр нутагтан, мөлхөгчдийн дэлхийн хэмжээнд томоохон популяци болдог ба Монгол Улс албан ёсоор нэгдэж, дагаж мөрдөх үүрэг хүлээсэн олон улсын байгаль хамгааллын хэд хэдэн конвенцэд орсон биологийн ховор зүйлүүд олон бий. Эдгээрээс олон улсын хэмжээнд ховордлын зэргээрээ өндөрт тооцогддог, устаж болзошгүй болон ховордсон зүйлийн жагсаалт, биологийн олон янз байдлын нарийн шүүлтүүрийн бүрдэл хэсэг болсон онцгой чухал зүйл амьтад говийн гайхамшигт 6 амьтанг байгалийн танхимд биетээр дэглэх, интерактив контент харуулсан мультимедиа контентийг хана дотор тусгай зориулалтын проекторууд ашиглан анимейшн хэлбэрээр үзүүлэх.


6.Суль, цулхирын гурил боловсруулах

Монгол Улсын яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн үндэсний бүртгэлд орсон суль, цулхирын гурил боловсруулах арга ухаан суль, цулхирын гурил хийх түүнийг хийх багаж хэрэгсэлийг зөв байруулах зэргийг үзэгчийн оролцоотойгоор хийдэг интерактив контентийг тусгай зориулалтын проектор болон touchscreen дэлгэц ашиглан үзүүлэх.

Тав: Музейн нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөө

Орчин үеийн стандартад нийцсэн музейн ажилтнууд болон судлаач, сонирхогчид, иргэдийн хүсэл эрмэлзлэлд нийцсэн, өв соёлын хадгалалт хамгаалалт сайжирч, сүүлийн үеийн дэвшилтэт техник хэрэгсэлтэй, танин мэдэхүйн таатай орчинтой, чадварлаг боловсон хүчинтэй болохын зэрэгцээ шинжлэх ухааны байгууллагуудтай хамтын ажиллагаатай судалгааны төв болоход оршино.

Ард иргэд, үйлчлүүлэгчид түүний дотроос хүүхэд залуучуудын чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх орон нутгаа танин мэдэх, шинжлэх ухаанд дурлах таньж мэдсэнээрээ хайрлах, бахархах, хамгаалах, бусдад түгээх, ухамсрыг дээшлүүлэх, түүх, соёл, өв уламжлалаараа бахархах үзлээр хүмүүжүүлэх, оюуны асар том хөрөнгө оруулалт болно.



7.

Орон нутагтаа байгууллага бие даан орлого олох эдийн засгийн хувьд чадамжтай болох боломж бүрдэнэ.

Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэхэд өөрийн орны түүх соёлын нэгзэхэн хэсгийг сурталчилан таниулах, аялал жуулчлалын маршрутад хамрагдана.

Зургаа: Үзүүлэлэг дэглэлтэд өөрчлөлт оруулах

Музейн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.2 дахь заалтуудыг үндэслэн шинэчлэх ба тухай бүрд нь нэмэлт өөрчлөлт оруулна.

__oOo__